



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/608

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад заасан нийт 274,761,572.82 (хоёр зуун далан дөрвөн сая долоон зуун жаран нэгэн мянга таван зуун далан хоёр төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, 58,195,862.90 (тавин найман сая нэг зуун ерэн таван мянга найман зуун жаран хоёр төгрөг ерэн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй, 8 тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” (Э.Болор-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар (П.Баттүшиг), Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа), Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв (М.Мөнгөнцэцэг), Нийслэлийн “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ (С.Батзаяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202948



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэр-лэсэн он	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагд-сан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Суудлын тээврийн хэрэгсэл	Toyota Harrier	31-68 УЕМ	MNU382073359	2009 2018	1	34,500,000.0	17,250,000.0	17,250,000.0	"Төр захиргааны авто бааз" УТҮГ	Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар
2	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёота приус	71-08 УАЕ	ZVW301392671	2011 2019	1	19,375,000.0	12,287,470.1	7,087,529.9		Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газар
3	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёота приус	65-14 УБП	ZVW305506696	2012 2018	1	18,300,000.0	9,150,000.0	9,150,000.0		Нийслэлийн Өмчийн харилцааны газар
4	Бага багтаамжин автобус	Хьюндай Старекс	81-66 УНУ	KMJWAN7JP8 U078776	2008 2010	1	35,000,000.0	17,791,667.0	17,208,333.0	"Төр захиргааны авто бааз" УТҮГ	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв
5	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёота приус	45-83 УНУ	NHW203571097	2010 2015	1	11,900,000.0	11,900,000.0	-		"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ
6	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёото Приус	37-14 УНС	ZVW301204566	2010 2017	1	15,000,000.0	7,500,000.0	7,500,000.0		"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ
7	Суудлын тээврийн хэрэгсэл	Лексус ЛС-460	77-15 УНУ	JTHGL46F485031547	2008 2008	1	114,400,000.0	114,400,000.0	-		"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ
8	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёота Хайлюкс	17-17 УНУ	TRN2150006085	2005 2014	1	26,286,572.8	26,286,572.8	-		"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ
Нийт дүн							274,761,572.82	216,565,709.92	58,195,862.9	-	-